



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 сарын 10 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

┌ Даатгалын байгууллагад аудит хийх ┐
эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 7 дугаар хавсралтын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Фин аз аудит” ХХК-д даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосугай.
2. Аудитын үйл ажиллагааны стандарт, хууль тогтоомжийн дагуу чанарын хяналтыг байгууллагадаа хэрэгжүүлж ажиллах, чанарын хяналт шалгалтын үнэлгээг тухай бүр Хороонд ирүүлэх, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Фин аз аудит” ХХК /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН